



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.08.06 № 1805

танай _____-ны № _____-т

**ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
НАМЫН ДАРГА
Ш.ТӨМӨРСҮХ ТАНАА**

Хандивын тайлангийн дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох “Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6, 26.4.6-д заасны дагуу иргэн хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь хандивын тайланг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлт

“Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам” 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

Z:\Yawan Bichig\2021\0805 ADD-22.Docx

80000004

01031768